

Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн
төвийн салбарууд байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 185 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудыг Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Бизнес инкубатор төв”-ийн байранд болон иргэд, оршин суугчдын төрийн үйлчилгээг авах эрэлт, хэрэгцээг судлан оновчтой байршилд тус тус байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шуурхай зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2.Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудыг байгуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Э.Содномжамц/-т, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М.Халиунбатад даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Нийслэлийн Инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
Дэд дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга -Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга -Нийслэлийн Архивын газрын дарга -Нийслэлийн Бүртгэлийн газрын дарга -Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга -Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга -Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга -Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга -Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга -Нийслэлийн Татварын газрын дарга -Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч -Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газрын дарга -Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал
Нарийн бичгийн дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга